



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 146

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Баттогтох (Хөдөө аж ахуй, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Б.Энхдэлгэр (Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн)

Ч.Баярмаа (Төрийн сангийн мэргэжилтэн)

Д.Ганчимэг (Татварын байцаагч)

Л.Мөнхжаргал (Иргэний төлөөлөл)

Б.Эрдэнэцэцэг (Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)

2.Багийн иргэдийн нийтийн хурлын тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг эрэмбэлэн, хэлэлцэж, дараагийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг хуулийн хугацаанд боловсруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Л.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

